**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

**2024.11.25** **Чойр**

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлсон зорилт, арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023 | | Зорилтот түвшин 2024 | | Гүйцэтгэл | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Жилийн эцэс | Эхний хагас жил | Жилийн эцэс | | |
| **НЭГ.**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | | | |
| 1 | **Зорилт:1** Малын болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах | УТХО БТ | Гүйцэтгэлийн тоон үзүүлэлтийн хувь, хэмжээ; | 100% | 100% 4078 | 100% 1000 | 100% 5100 | ХХААХҮЯ-ны 08-00-02/03 дугаартай “Хүнсний аюулгүй байдал” 3 сарын аяны хүрээнд урьдчилан сэргийлэх чиглэлээр 12, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 4, өргөтгөсөн үзэсгэлэн худалдааны 10 цэг, зах худалдааны төвийн 9 иргэн, аж ахуйн нэгжийн хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хадгалалт, баталгаат байдал болон хугацаа, хаяг, шошгын бүрэн бүтэн байдал зэрэгт хяналт, шалгалт хийхэд хадгалах, хэрэглэх хугацаа хэтэрсэн, хадгалалтын горим баримтлаагүйгээс чанар, аюулгүй байдал нь алдагдсан 4 нэр төрлийн 80ш, 3.065кг нийт 774678 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хүнсний худалдаанаас татан авч, “Хүнсний тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 157 дугаар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дотоод хяналт хэрэгжүүлэх" тогтоолын дагуу газар дээр нь устгаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэв. Хяналтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах 6 заалт бүхий улсын байцаагчийн 2 албан шаардлагыг 2 аж ахуй нэгжид өгч биелэлтийг тооцож ажилласан. Малаас хүнд халдварладаг зоонозын халдварт өвчний шинжилгээнд 3100 толгой мэдрэмтгий мал хамруулж, халдварын түвшинг тогтоон баталгаажуулсан. | |
| 1.1 | Бруцеллёз, сүрьеэ, лейкоз өвчингүй, тайван байдлаа хадгалах, баталгаажуулах тандалтын ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцож тайлагнах. | УТ | Шинжилгээнд хамруулсан дээжийн тоо; | 0 | 4078 | 1000 | 5100 | Малаас хүнд халдварладаг зоонозын халдварт бруцеллёзын шинжилгээнд 3100 толгой мал хамруулахаар төлөвлөсөн ба 3100 толгой мэдрэмтгий мал хамруулж, гүйцэтгэл 100%. Шинжилгээний дүнгээр 3100 дээж сөрөг дүн үзүүлж, бруцеллёзоор эрүүл болохыг тогтоон баталгаажуулсан. Мөн үхрийн сүрьеэ, адууны ямыг илрүүлэх шинжилгээнд нийт 2000 толгой үхэр ба адууг хамруулахаар төлөвлөн ямлуур, сүрьеэлүүрийг захиалсан боловч нийлүүлэгдээгүй. Үхрийн сүрьеэ, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | лейкоз, адууны ямаар тайван байдлаа хадгалсан. | |
| 1.2 | Мал, амьтны өвчнийг тандах, эрт илрүүлгийн арга хэмжээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, хяналт тавих, баталгаажуулах, үр дүнг үнэлэх | БТ | Идэвхитэй тандалт хийсэн өрхийн тоо; Идэвхигүй тандалт хийсэн өрхийн тоо; Эрт илрүүлэг цэсэнд мэдээлсэн өрхийн тоо; | 77<br>208<br>351 | 77<br>208<br>590 | 37<br>222<br>147 | 150<br>250<br>540 | Гоц халдварт хонины цэцэг, бог малын мялзангийн тандалт судалгааг энэ оны 01 сарын 15-ны өдрөөс 6 удаа идэвхитэй ба идэвхигүй хэлбэрээр зохион байгуулсан. Тандалтанд эрсдэлтэй бүс нутгийн нийт 463 хот айлыг хамруулсан ба 168726 толгой мэдрэмтгий малд эрүүл мэндийн ерөнхий үзлэг хийсэн. Тандалтаар хонины цэцэг, бог малын мялзангийн сэжиг таамаг илрээгүй. Гоц халдварт 4 төрлийн өвчний эрт илрүүлгийн үзлэг, тандалтыг 6 МЭҮН сар бүр өөрийн гэрээт малчин өрхийн мэдрэмтгий малд хийсэн ба 11 сарын 25-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 120 өрхийн 13799 толгой малд эрт илрүүлгийн үзлэг хийж, нийт 583 өрхийг МЭНС-д мэдээлсэн. Үүнд: Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж, зөвлөмж арга зүйгээр хангаж ажилласан. | 100% |
| 1.3 | Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 11 объектод төлөвлөгөөт шалгалт хийх. | БТ | Хяналт шалгалт хийсэн объектын тоо гүйцэтгэлийн хувь; илрүүлсэн зөрчил арилгуулалтын хувь; Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт; Эрсдэлийн | 0 | 8 | 5 | 11 | Засгийн газрын 2023 оны 420 дугаартай тогтоолын “Салбарын хяналт, шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-ний 10 дугаар заалтын дагуу ХХААХҮЯ-ны СХГ-ын 2024.03.26-ны өдрийн 08-00-02/16 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалт, болон “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын хэрэгжилтийн үзлэг зохион байгуулах” нэгдсэн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | түвшин буурсан объектын тоо хувь; | | | | | удирдамжийн дагуу 3 суманд үйл ажиллагаа явуулж буй 5 МЭҮН-ийг хамруулж эрсдлийг тогтоон зөвлөмж арга зүйгээр хангасан. Тус хяналт, шалгалтын хүрээнд бага эрсдэлтэй үнэлэгдсэн 5 МЭҮН-ийн мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх эрх нь хэвээр хадгалагдсан. 2023 онд үйл ажиллагаа явуулж байсан 6 МЭҮН-ийн үйл ажиллагааг өөрсдийн хүсэлтээр зогсоосон. "Салбарын хяналт, шалгалтын 2024 оны төлөвлөгөө"-ний 10 дугаар заалтын дагуу ХХААХҮЯ-ны СХГ-ын 2024.03.13-ны өдрийн 08-00-02/09 дугаартай мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр цехийн үйл ажиллагаа эрхлэж буй 1 иргэн, 1 ААН-д төлөвлөгөөт хяналт, шалгалт хийсэн ба 48 зөрчил илрүүлж, 24 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 24 заалт бүхий албан шаардлага өгч зөрчлийг арилгуулсан. | |
| 1.4 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, эрсдэлийг бууруулах | БТ | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт (хувь);<br>Эрсдэл үүсэх магадлалын бууралт (хувь);<br>Зөрчил арилгуулалт (хувь);<br>Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувь); | 0 | 0 | Өргөдөл, гомдол барагдуулалт 100% | Өргөдөл, гомдол барагдуулалт 100% | Иргэнээс ирүүлсэн 4 гомдол мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж хоол үйлдвэрлэлд хэрэглэж байсан мах болон хоолыг шинжилгээнд хамруулан хугацаатай албан шаардлага өгсөн. Мөн 3 иргэний гомдлын дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, Зөрчлийн тухай хуулиар нийт 400,000 төгрөгийн шийтгэл ногдуулсан ба зөрчлийг дахин давтахгүй байх талаар зөвлөмж арга зүй өгсөн. | 100% |
| 1.5 | Иргэн, аж ахуйн | БТ | Зөвлөн туслах | 0 | 0 | Зөвлөн | Зөвлөн | Засгийн газрын 2023 оны 420 дугаар | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгж, байгууллагын хүсэлтээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | | үйлчилгээ авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тооны өсөлт; Зөвлөмжийн биелэлт (хувь); Зөвлөн туслах үйлчилгээний биелэлт; Хууль сахин мөрдөлт; Эрсдэл үүсэх магадлал; | | | туслах үйлчилгээний гүйцэтгэл 100% | туслах үйлчилгээний гүйцэтгэл 100% | тогтоол "Салбарын хяналт, шалгалтын 2024 оны төлөвлөгөө"-ний 97 дугаар заалтын дагуу ХХААХҮЯ-ны СХГ-ын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 08-00-03/17 дугаартай төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Сүмбэр сумын 5 дугаар багт МЭҮН-ийн үйл ажиллагаа явуулах хүсэлт гаргасан "Улзын чулуун булаг" ХХК, Шивээговь суманд мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан "Алтан тахилга" ХХК-нд тус тус төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул цаашид хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | 100% |
| 1.6 | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалтыг хэрэгжүүлэх | БТ | Тухайн жилийн шаардлага хангаагүй шинжилгээний үзүүлэлтийн бууралт (хувь); Урьдчилан сэргийлэх шалгалт (асуудлын тоо); Тухайн жилийн хяналт шинжилгээ биелэлт (хувь); | 0 | 0 | УСХШ-ын гүйцэтгэл 100% | УСХШ-ын гүйцэтгэл 100% | ХХААХҮЯ-ны СХГ-ын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/03 дугаартай төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтад хүнсний худалдааны 12, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 57, өргөтгөсөн үзэсгэлэн худалдааны 10 цэг, зах худалдааны төвийн 9 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Хяналтаар хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хадгалалт, бүтээгдэхүүний баталгаат болон эдэлгээний хугацаа, хүнсний бүтээгдэхүүний хаяг, шошгын бүрэн бүтэн байдал, хадгалах, хэрэглэх хугацаа хэтэрсэн, хадгалалтын горим баримтлаагүйгээс чанар, аюулгүй байдал нь алдагдсан 8 нэр төрлийн 544ш, 11.478 кг нийт 1,926,321 төгрөгийн хүнсний | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүтээгдэхүүнийг худалдаанаас татан авч, “Хүнсний тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 157 дугаар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх” тогтоолын дагуу газар дээр нь устгаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн. Хяналтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах 6 заалт бүхий улсын байцаагчийн 2 албан шаардлагыг 2 аж ахуйн нэгжид өгч зөрчил дутагдлыг арилгуулсан. | |
| 1.7 | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналтыг хэрэгжүүлэх | БТ | Чанарын хяналтад хамрагдсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийт хэмжээ (мян.тоо) | 4 | 7 | Зөрчил барагдуулалт 100% Шийдвэрийн биелэлт 100% | Зөрчил барагдуулалт 100% Шийдвэрийн биелэлт 100% | Сүмбэр, Шивээговь сумдад мах бэлтгэж буй мал нядалгааны 5 цэгт давхардсан тоогоор 11 удаа хяналт, шалгалт явуулж, 4 иргэний мал төхөөрөх цэгийн үйл ажиллагааг түр зогсоож, Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч 1,000,000 төгрөгийн торгууль ногдуулж, мал эмнэлэг ариун цэврийн шаардлагыг сайжруулсан. Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтарч 2023-2024 онд хүн амын махны хэрэгцээнд зориулж мах нөөцөлсөн 8 иргэн, ААН-ийн 106тн махны хадгалалт болон худалдаалалтын явцад мал эмнэлэг, ариун цэврийн эрүүл ахуйн шаардлагыг хангуулах чиглэлээр хяналт, шалгалт хийн, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн ба 1 ААН-д 8 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулсан. Тус хяналт шалгалтаар махны эрүүл, аюулгүй байдал, | 100% |
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилт (хувь) | 100% | 100% | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хадгалалт, хамгаалалт, орчны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал зэргийг үзэж 8 төрлийн зөрчил дутагдал илэрснийг газар дээр нь арилгуулж, зөвлөмж арга зүйгээр хангаж ажилласан. | |
| 1.8 | Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малчдын хамтын ажиллагааг сайжруулж, мал, амьтны өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | БТ | Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо | 153.9 | 396.7 | 139.5 | 458.0 | -Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 458.0 мян.тол мал хамруулахаас 84.09 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 18.3%<br>-Ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 төрлийн дархлаажуулалтад 74.4 мян.тол мал хамруулахаас 46.9 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 63%.<br>-Гоц халдварт шүлхий, богийн мялзангийн тандалт шинжилгээнд Баянтал, Сүмбэр, Шивээговь сумын нийт 30 өрхийн 480 толгой мэдрэмтгий малыг шүлхийн, 360 толгой богийг мялзангийн шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний үр дүнгээр бог малын мялзангийн байгалийн халдвар илрээгүй, харин шүлхийн байгалийн халдвар 1 дээжинд илэрч халдварлалт 0,2% байгааг тогтоон баталгаажуулсан ба холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br>-Улсын хэмжээнд намжмал байдалд шилжээгүй мал, амьтны гоц халдварт өвчин мэдрэмтгий мал сүрэгт тохиолдоогүй, тайван статусыг хангасан.<br>-Сүмбэр сумын 4, 5, 6-р багийн иргэдийн нийтийн хурал энэ оны 05 сарын 10, 11, 12-ны өдрүүдэд зохион | 100% |
| | | | Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо | 37.8 | 80.3 | 68.0 | 74.4 | | |
| | | | Мал амьтаны халдварт өвчний тандалт, шинжилгээний тоо | - | 980 | 100 | 820 | | |
| | | | Мал амьтны гоц халдварт өвчний гаралт | 2 | 0 | - | - | | |
| | | | Сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо | 4 | 4 | 3 | 5 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулагдсан ба байгууллагын удирдлага, баг хариуцсан гэрээт малын эмч нар оролцож, мал эмнэлгийн цаг үеийн ажлаар мэдээлэл өгч 5 төрлийн 500 ширхэг гарын авлага олгосон. Уг арга хэмжээнд 270 малчин хамрагдсан. Хуралд оролцсон малчдаас ОНХС-ийн хөрөнгөөс 4, 5, 6-р багт мал угаалгын ванныг шинээр барих, малын тоо толгойн албан татварын төвлөрсөн хөрөнгөөс малчид өөрсдөө хариуцдаг 3 төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, мал угаалгын зардлыг шийдвэрлэх талаар санал гаргаж, эхний 5 арга хэмжээнд эрэмбэлэгдсэн. Мөн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр “Мал эмнэлгийн байгууллагын эмч, мэргэжилтний зөвлөгөөн”-ийг зохион байгуулж 20 эмч, мэргэжилтэн хамрагдсан. Зөвлөгөөнөөр Мал эмнэлгийн газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан түүний үр дүн, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, сайжруулах ажлын талаар мэдээлэл өгч оролцогсдын санал, хүсэлтийг хүлээн авч хариу өгсөн. Зудын гамшгийн үед нөлөөллийн арга хэмжээг нийт 364 өрхөд (731 хүн) зохион байгуулж, 20731 малд эрүүл мэндийн ерөнхий үзлэг хийж 289 малд анхны тусламж үзүүлсэн.<br>**Тайлбар:Зудын гамшгийн улмаас малын тоо толгой эрс буурсан нь мал эмнэлгийн ажил үйлчилгээний гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлсэн.** | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9 | Мал амьтаны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд нь зохион байгуулах | ОНТ 29.5 сая | Вакцинд хамруулсан малын тоо (мян.тол); | 37.8 | 80.3 | 68 | 74.4 | Биокомбинат ТӨХХК-аас халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 төрлийн вакцин нийлүүлэгдсэн. Ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 төрлийн дархлаажуулалтад 74.4 мян.тол мал хамруулахаас 46.9 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 63%. **Тайлбар:Зудын гамшгийн улмаас малын тоо толгой эрс буурсан нь мал эмнэлгийн ажил үйлчилгээний гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлсэн.** | 100% |
| | | | Вакцинжуулалтын гүйцэтгэлийн хувь; | 100% | 94.4% | 100% | 100% | | |
| 1.10 | Харъяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг болон зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, гоц халдварт, халварт өвчний голомтын, сэжигтэй бүсийн бэлчээр, ус эх булаг, малын бууц, хашаа хороог цэвэрлэх, халдваргүйтгэх арга хэмжээг зохион байгуулах | | Халдваргүйтгэлд хамруулсан талбайн хэмжээ $м^2$ | 50.6 | 85.2 | 44.0 | 88.0 | Мал аж ахуйн 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, зудын гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг булж устгах үйл ажиллагааг 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Сүмбэр, Баянтал, Шивээговь суманд зохион байгуулж, 04 сарын 26-ны өдөр 93.3%-ийн гүйцэтгэлтэй дууссан. Уг арга хэмжээнд нийт 111551ш сэг зэмийг устгалын 18 цэгт булж устгасан. Үүнд давхардсан тоогоор 141 автомашин, 256 хүн ажиллаж, нийт 5200$м^2$ талбайг халдваргүйжүүлж, 571кг халдваргүйтгэлийн бодис ашигласан ба үйл ажиллагааны зардалд 154,3 сая төгрөг зарцуулсан. Мөн мал эмнэлэг, ариун цэврийн төлөвлөгөөт халдваргүйтгэлд МАА-н 112 цэгийн 68065м2 талбайг халдваргүйжүүлж, гүйцэтгэл 77%. Сэг зэм устгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг 33 удаа хэрэгжүүлсэн ба зөвлөмж арга зүйг урьдчилсан | 100% |
| | | | Гүйцэтгэлийн хувь | 100% | 97% | 50% | 100% | | |
| | | | Гүйцэтгэлийн хяналтын тоо | 1 | - | 33 | 3 | | |
| | | | Илрүүлсэн зөрчилийн тоо, шийдвэрлэлт | 0 | 0 | 0 | 3 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байдлаар болон газар дээр нь өгч ажилласны үр дүнд зөрчил дутагдал илрээгүй, гүйцэтгэл 100%. | |
| 1.11 | Сумын Мал эмнэлгийн тасгийг холбогдох хуулийн дагуу мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, бүтэц орон тоогоор нь ажиллуулах, Орон нутгаас Малын эмчийг ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуультай гэрээ байгуулан захиалгаар сургах ажлыг зохион байгуулах | БТ | Бүтэц орон тоог бүрдүүлсэн сумын тоо | 0 | 1 | 1 | 1 | Аймгийн төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалгыг тухай бүр хүргүүлж, иргэний өрсөлдөх боломжийг хангасан ба орон нутагт малын эмч авч ажиллуулах талаар ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуультай хамтран ажиллаж 1 шинэ залуу төгсөгчийг шинжлэгч их эмчийн ажилд томилон сул орон тоог нөхсөн. Мөн Шивээговь сумын МЭТ-т тархвар зүйч, Сүмбэр сумын МЭТ-т тархвар зүйч, МЭХ-ын улсын байцаагч нарыг томилгоожуулж, 3 сул орон тоог нөхсөн ба Сүмбэр сумын МЭТ-ийн орон тоог бүрдүүлсэн. | 100% |
| **ХОЁР.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | | |
| 2 | **Зорилт:2** Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөн, баталгаажуулалтанд хяналт тавьж, мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийн шинжилгээг хийж, чанар аюулгүй байдлыг хангах | БТ | Мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний үзүүлэлтийн тоо; | 1-7 | 1-8 | 1-9 | 1-9 | Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 12 удаа хяналт тавьж давхардсан тоогоор иргэн, аж ахуйн нэгжийн нийт 682 сорьцонд тус бүр 2-9 арга зүйн дагуу мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээ хийж, 3150ш өндөг, 236.4тн мах, 8.5тн цагаан идээний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулсан. Шинжилгээний дүнгээр бүх сорьц стандартад нийцэж эрүүл аюулгүй болох нь тогтоогдсон. | 97.9% |
| | | | Лабораторийн шинжилгээгээр баталгаажуулсан мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний тоо; | 433 | 656 | 393 | 722 | | |
| | | | МЭҮН-ийн гарал үүслийн гэрчилгээгээр баталгаажсан | 5.8% | 25% | 6% | 30% | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | түүхий эд, бүтээгдэхүүний хувь; | | | | | | |
| 2.1 | Мал, малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах | - | Олгосон мал эмнэлгийн гэрчилгээний тоо; | 880 | 1967 | гүйцэтгэл | гүйцэтгэл | Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж буй 5 МЭҮН-ийн 7 малын эмч мал, малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнд олгох гэрчилгээг цахимаар үйлдэж хэвшсэн ба 11 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 1600 цахим гэрчилгээ олгон эрүүл аюулгүй байдлыг баталгаажуулсан байна. Үүнд: Амьд мал 134803 толгой, мах, махан бүтээгдэхүүн 108.6тн, гулууз 6231ш, арьс 17050ш, ноолуур 39.0 тн, 53.8тн ноос, дайвар бүтээгдэхүүн 530ш хамрагдсан байна. | 100% |
| | | | Баталгаажуулсан эх материалын хэмжээ: Үүнд: Амьд малын тоо; | 4362 | 18682 | гүйцэтгэл | гүйцэтгэл | | |
| | | | Сүү, сүүн бүтээгдэхүүн, литр; | 1696 | 80 | гүйцэтгэл | гүйцэтгэл | | |
| | | | Мах, махан бүтээгдэхүүн, тн; | 19,6 | 408 | гүйцэтгэл | гүйцэтгэл | | |
| | | | Гулуузны тоо, ш; | 230 | 11385 | гүйцэтгэл | гүйцэтгэл | | |
| | | | Арьсны тоо, ш; | 16071 | 11385 | гүйцэтгэл | гүйцэтгэл | | |
| | | | Ноосны хэмжээ, тн; | 648 | 120 | гүйцэтгэл | гүйцэтгэл | | |
| | | | Ноолуурын хэмжээ, тн; | 10,2 | 7 | гүйцэтгэл | гүйцэтгэл | | |
| | | | Дайвар бүтээгдэхүүний тоо, ш; | 1649 | 1854 | гүйцэтгэл | гүйцэтгэл | | |
| 2.2 | Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд ариун цэврийн шинжилгээ хийх, баталгаажуулах | БТ | Шинжилсэн махны сорьцийн тоо; | 165 | 200 | 133 | 365 | Махны 360 сорьцонд шинжилгээ хийж 236.4тн махны эрүүл байдлыг баталгаажуулсан ба гүйцэтгэл 98.6%. Сүү, сүүн бүтээгдэхүүний 112 сорьцонд шинжилгээ хийж 8.5тн цагаан идээний эрүүл байдлыг | 98.1% |
| | | | Шинжилсэн сүү, цагаан идээний сорьцийн тоо; | 50 | 64 | 0 | 120 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шинжилсэн өндөгний сорьцийн тоо; | 50 | 160 | 90 | 210 | баталгаажуулсан ба гүйцэтгэл 93.3%. Өндөгний 210 сорьцонд шинжилгээ хийж 3150ш өндөгний эрүүл байдлыг баталгаажуулсан ба гүйцэтгэл 100%. МЭАЦ-ийн шинжилгээний төлбөрөөс 2,643,300 төгрөгийн орлого бүрдүүлж төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. | |
| 2.3 | Зах зээлд борлуулагдаж байгаа түүхий мах, сүүнд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээ хийх | УТХО | Шинжилсэн сорьцын тоо; | 18 | 82 | 20 | 120 | Мал, амьтнаас гаралтай түүхий маханд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээг ЭЛИЗА болон түргэвчилсэн тестийн арга зүйгээр 110 сорьцонд хийсэн ба гүйцэтгэл 91.6%. Шинжилгээний үр дүнгээр маханд антибиотикийн үлдэгдэл илрээгүй. | 91.6% |
| 2.4 | Хүн амын хүнсний хэрэгцээнд сүү, цагаан идээ нийлүүлдэг малчин өрхийн саалийн малд бруцеллёзын шинжилгээ хийх | БТ | Шинжилсэн сорьцийн тоо; | 150 | 150 | 150 | 150 | Хүн амын хүнсний хэрэгцээнд сүү, цагаан идээ нийлүүлдэг малчин өрх, саалийн малын судалгааг гаргаж нийт 150 толгой саалийн малд бруцеллийг илрүүлэх шинжилгээнд хамруулахад бүгд сөрөг дүн үзүүлсэн ба гүйцэтгэл 100% | 100% |
| 2.5 | Малчид, иргэд, малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үйлчилгээ эрхлэгч иргэн, ААН-д хандсан нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, оролцох. | БТ | Оролцсон арга хэмжээний тоо;<br>Зохион байгуулсан сургалт, мэдээллийн тоо;<br>Пэйж хуудсанд оруулсан мэдээллийн тоо;<br>Цахим хандалтын тоо; | 3<br>0<br>0<br>0 | 1<br>2<br>0<br>0 | 3<br>1<br>15<br>гүйцэтгэл | 5<br>2<br>30<br>гүйцэтгэл | Малчид, иргэд, малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үйлчилгээ эрхлэгч иргэн, ААН-д дараах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж мэдээллээр хангасан. Үүнд: Сүмбэр сумын 4, 5, 6-р багийн иргэдийн нийтийн хурал, 6-р багийн малчдын уулзалтад оролцож мал эмнэлгийн цаг үеийн ажил, үйлчилгээ, малын гоц халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх мэдээ, мэдээлэл хүргэхийн зэрэгцээ адууны ям, томуу, зарим шимэгч хорхой, нийлүүлгийн өвчин, халдваргүйтгэл | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | түүний ач холбогдол бүхий нийт 500ш гарын авлага олгосон. Тус арга хэмжээнд 270 малчин хамрагдсан. Мөн байгууллагын цахим хуудас, пэйж хуудсаар дамжуулан зорилтот бүлгэд мэдээ, мэдээлэл хүргэж хэвшсэн ба тэдэнд хандсан 44 мэдээлэл байршуулж, хандалтын тоо 542 байна. | |
| **ГУРАВ.ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | | |
| 3.1 | **Зорилт:3** Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | УТХО МАӨХ БТ | Мал, амьтны халдварт, паразиттах өвчнөөр тайван статусыг хангасан сумын тоо; | 3 | 3 | 3 | 3 | Мал, амьтны халдварт паразиттах өвчнөөр тайван статусыг аймгийн хэмжээнд буюу Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдад хангасан. | 80% |
| 3.1.1 | Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх | УТХО 174.1 сая | Вакцинд хамруулсан малын тоо, мян.тол; | 18.6 | 612.8 | 20.5% | 472.3 | Гоц халдварт шүлхийн эсрэг хаврын дархлаажуулалтад 14.4 мян.тол мал амьтан хамруулахаас 11.4 мян.тол үхэр ба гахай хамруулж, гүйцэтгэл 79%. Гоц халдварт хонины цэцгээс сэргийлэх дархлаажуулалтад 220.0 мян.тол хонь хамруулахаас 113.5 мян.тол хонь хамруулж, гүйцэтгэл 51%. Гоц халдварт бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 184.7 мян.тол мал хамруулахаас 113.3 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 61%. Нэгдсэн дүнгээр гоц халдварт 3 төрлийн өвчнөөс сэргийлэх 3 төрлийн дархлаажуулалтад нийт 238.2 мян.тол буюу хамруулбал зохих бүх | 100% |
| | | | Вакцинжуулалтын гүйцэтгэлийн хувь; | 96% | 100% | 100% | 100% | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мэдрэмтгий малыг хамруулж, эрсдлээс сэргийлсэн. Дархлаажуулалтын үр дүнд мал, амьтны гоц халдварт өвчнөөр тайван статустай байна. **Тайлбар:Зудын гамшгийн улмаас малын тоо толгой эрс буурсан нь мал эмнэлгийн ажил үйлчилгээний гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлсэн.** | |
| 3.1.2 | Малаас хүнд халдварладаг зоонозын халдварт бруцеллёзоос сэргийлэх дархлаажуулалтыг технологит хугацаанд нь зохион байгуулах | ОХТХО 40.4 сая | Бруцеллёзын эсрэг вакцинд хамруулсан малын тоо, мян.тол; | - | 91.1 | - | 93.0 | Малаас хүнд халдварладаг зоонозын халдварт бруцеллёзоос сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/329 дүгээр захирамжийн дагуу зохион байгуулж, мэдрэмтгий 94.34 мян.тол төл мал хамруулахаас 22.4 мян.тол шинэ төлийг хамруулж, гүйцэтгэл 25%. **Тайлбар:Зудын гамшгийн улмаас төллөх эх малын тоо толгой эрс буурсан нь мал эмнэлгийн ажил үйлчилгээний гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлсэн.** | 70% |
| | | | Вакцинжуулалтын гүйцэтгэлийн хувь; | | 98% | | 100% | | |
| 3.1.3 | Малыг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах | МАӨХ | Угаалганд хамруулсан малын тоо, мян.тол; | - | 195.5 | - | 178.1 | Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд нийт 458.0 мян.тол мал хамруулахаас 84.09 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 18.3%. **Тайлбар:Зудын гамшгийн улмаас малын тоо, толгой эрс буурсан ба малчин өрхийн санхүү, сэтгэл зүйн байдалд эрс өөрчлөлт орсон нь шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний гүцэтгэлд сөрөг нөлөө үзүүлсэн. Эмийн бодис болон Ажил үйлчилгээний хөлсийг малчид** | 70% |
| | | | Гүйцэтгэлийн хувь; | | 85% | | 100% | | |
| | | | Боловсруулалтанд хамруулсан малын тоо, мян.тол; | 66.0 | 78.8 | 60.0 | 120.9 | | |
| | | | Гүйцэтгэлийн хувь; | 50% | 46% | 50% | 100% | | |
| | | | Туулгалтанд | 87.9 | 122.4 | 79.5 | 159.0 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамруулсан малын too, мян.тол; | | | | | **хариуцдаг.** | |
| | | | Гүйцэтгэлийн хувь; | 50% | 70% | 50% | 100% | | |
| 3.2 | **Зорилт:4** Гоц халдварт, халдварт, халдваргүй өвчний байгалийн халдвар, өвчлөлийг лабораторийн тандалт шинжилгээгээр илрүүлж, гаралт тархалтаас урьдчилан сэргийлэх | УТХО БТ | Гоц халдварт, халдварт, өвчний байгалийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсан малын тоо; | 480 | 3065 | 100 | 2620 | Гоц халдварт шүлхий, богийн мялзан, зоонозын халдварт боом, бруцеллёзын тандалт шинжилгээнд нийт 2943 ширхэг дээж хамруулж, гаралт тархалтаас урьдчилан сэргийлсэн ба гүйцэтгэл 100%. | 100% |
| 3.2.1 | Мал, амьтны гоц халдварт өвчний тандалт шинжилгээг зохион байгуулах | УТХО | Шүлхийн байгалийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсан малын тоо; | - | 480 | - | 320 | Гоц халдварт шүлхийн байгалийн халдварыг илрүүлэх тандалт шинжилгээнд Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын нийт 30 өрхийн 480 толгой үхэр хамруулж, гүйцэтгэл 100%, Богийн мялзангийн байгалийн халдварыг илрүүлэх тандалт шинжилгээнд Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын нийт 30 өрхийн 360 толгой мэдрэмтгий малыг хамруулж, гүйцэтгэл 100%. | 100% |
| 3.2.2 | Малаас хүнд халдварладаг зоонозын халдварт өвчний байгалийн халдварыг илрүүлэх тандалт шинжилгээг | УТХО | Боомын шинжилгээнд хамруулсан малын тоо; | - | 500 | 100 | 500 | Хүнд халдварладаг зоонозын халдварт боомын шинжилгээнд 500 сорьц бэлтгэн хамруулахад бүгд сөрөг дүн үзүүлж, боомоор эрүүл, аюулгүй байдлыг тогтоон баталгаажуулсан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | | | | | | |
| 3.3 | **Зорилт:5**<br>Мал эмнэлгийн лабораторийг MNS ISO/IEC 17025:2018 сорилт болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага стандартын дагуу итгэмжлэлд хамруулах ажлыг эхүүлэх | УТХО БТ | Мал эмнэлгийн лабораторийг итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажлын гүйцэтгэлийн хувь; | - | - | 20% | 60% | Мал эмнэлгийн лабораторийг MNS ISO/IEC 17025:2018 сорилт болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага стандартын дагуу итгэмжлэлд хамруулахад шаардагдах зардлын тооцооллыг гаргаж УМЭАЦТЛ, МЭЕГазарт хүргүүлсэн. Төлөвлөсөн бэлтгэл ажлын гүйцэтгэл 100% | 100% |
| 3.3.1 | МЭЛ-ийн итгэмжлэлд бэлтгэх | БТ | Дээд шатны лабораторид дадлагажуулсан эмчийн тоо;<br>Шинэчилсэн бүртгэл, журналын тоо;<br>Ажлын байранд зохион байгуулсан сургалтын тоо; | 0 | 0 | 1<br>6<br>0 | 1<br>6<br>1 | Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид “Ийлдэс, молекул биологи, нян судлалын шинжилгээний арга зүй, лабораторийн биоаюулгүй ажиллагааны дүрэм, журам”-ын талаар хуанлийн 30 хоногийн хугацаанд 1 эмчийг сургаж, дадлагажуулсан ба оношлогоо, шинжилгээний арга зүй, ур чадвар эзэмшүүлсэн.<br>-Лабораторид хөтлөх 6 бүртгэл журналыг шинэчилж бүртгэлийг тогтмол хөтөлж түүнд хяналт тавин ажиллаж хэвшсэн.<br>-Мал, амьтнаас сорьц авах шимэгчтэх өвчний шинжилгээний арга зүй эзэмшүүлэх ажлын байран дахь сургалтыг зохион байгуулж, МЭГ, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | МЭТ-ийн нийт 6 эмчийг бүрэн хамруулсан. | |
| 3.3.2 | Лабораторийн оношлогоо шинжилгээний чадавхийг сайжруулах | УТХО БТ | Ур чадварын сорилд хамрагдсан тоо; | - | 4 | - | 5 | УМЭАЦТЛ-оос ирүүлсэн удирдамжийн дагуу дотоод хяналтын ур чадварын нийт 13 сорилыг хүлээн авч оношлогоо шинжилгээг аймгийн лабораторид шинжлэгч эмч нар хамтран хийж ур дүнг УМЭАЦТЛ-т хүргүүлж шалгуулсан ба “ХАНГАЛТТАЙ” үнэлэгдсэн. Үүнд: нян судлалын 3, ийлдэс судлалын 2, гоц халдварт өвчний 5, шимэгч судлалын 2 хүнсний нян судлалын 1 нийт 13 тест хамрагдсан ба шинжилгээг стандартын дагуу хийж оношлогоо шинжилгээний ур чадварыг сайжруулсан. | 100% |
| 3.4 | **Зорилт:6** Мал эмнэлгийн үйлчилгээний технологийн мөрдөлтөд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр хяналт тавьж, үр дүнг тооцох | БТ | Хяналт шалгалтын тоо; | 8 | 14 | 8 | 20 | Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний технологийн мөрдөлтөнд хяналт тавьж, 14 өрхийн мэдрэмтгий малыг нөхөн вакцинжуулах, ажил үйлчилгээний технологийг мөрдөөгүй нэг МЭҮН-ийг илрүүлж, нийт 3.6 сая төгрөгийн шийтгэвэр ногдуулах арга хэмжээ авч ажилласан. | 100% |
| 3.4.1 | Малчин өрхийн өвөлжилт, хаваржилт, отор нүүдэл, малын эрүүл мэндийн нөхцөл байдалд хяналт хийж, зөвлөн | БТ | Хяналтанд хамруулсан сум, багийн тоо; | 3/5 | 3/5 | 3/5 | 3/5 | Зудын гамшгийн үед 3 сумын нийт 364 малчин өрхөд биечлэн очиж 20731 малд эрүүл мэндийн ерөнхий үзлэг хийсэн ба 289 малд мал эмнэлгийн анхны тусламж үйлчилгээ үзүүлсэн. Сүмбэр сумын 5, 6-р багийн 40 малчин өрхөд малын эмийн багцыг үнэ | 100% |
| | | | Биечлэн очсон малчин өрхийн тоо; | 91 | 351 | 100 | 360 | | |
| | | | Зөрчил шалган | 0 | 0 | 0 | 6 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | туслах үйлчилгээ үзүүлэх | | шийдвэрлэсэн тоо; | | | | | төлбөргүй олгосон. Багцын зардал 1,200,000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэсэн. Малчин өрхийн отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг 05 дугаар сарын 01-15-ны өдрүүдэд хөдөлгөөнт эргүүлийн хэлбэрээр хэрэгжүүлсэн ба Шивээговь сумын нутаг дэвсгэрт отроор орж ирсэн 4 өрхөд ажиллаж нутаг чөлөөлөх, Дундговь аймгийн Сайнцагаан сумаас отроор ирсэн 1 малчин өрхийг Зөрчлийн тухай хуулийн 13.9.2 дахь заалтыг үндэслэн 50,000 төгрөгөөр торгох арга хэмжээ авсан. | |
| 3.4.2 | МЭҮН-ийн гүйцэтгэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг малчны хотонд хэрэгжүүлэх | БТ | Гүйцэтгэлийн хяналтын тоо; | 8 | 14 | 8 | 20 | МЭҮН-ийн гүйцэтгэсэн гоц халдварт бог малын мялзан, хонины цэцэг, шүлхийгээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын гүйцэтгэлд нийт 20 удаагийн хяналт, шалгалтыг зохион байгуулж, 480 малчин өрхөд биечлэн очиж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Хяналт шалгалтаар гоц халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад мэдрэмтгий малаа хамруулаагүй 14 өрхийг илрүүлж, нөхөн вакцинжуулалтын ажлыг зохион байгуулсан. Мөн Сүмбэр сумын Хуягт халтар МЭҮН-ийн гүйцэтгэсэн дархлаажуулалтын гүйцэтгэлд зөрчил илэрч гомдол мэдээллээр бүртгэж Зөрчлийн тухай хуулийн 13.9.6.1, 13.9.6.2 дахь заалтыг үндэслэн 2000 нэгж буюу 2.000,000 төгрөгийн шийтгэл ногдуулсан. Тус зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээний | 100% |
| | | | Малчин өрхийн тоо; | 336 | 446 | 340 | 580 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, шингэлэгчийн нийт 1,616,917 төгрөгийг нөхөн төлүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангаж ажилласан. | |
| 3.5 | **Зорилт:7** Дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт судалгаа, лабораторийн шинжилгээний аргаар үнэлж, хянах | УТХО | 2-3 нэр төрлийн вакцины дараах мониторинг шинжилгээнд хамруулсан малын тоо; | - | 126 | - | 180 | Мэргэжлийн удирдах дээд байгууллагын бодлого, шийдвэрийн дагуу Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын нийт 9 малчин өрхийн 27 үхрийг шүлхийн эсрэг вакцины дараах дархлаа тогтоох шинжилгээнд хамруулж, үр дүнг тооцож ажилласан. Харин бруцеллёз, богийн мялзангийн вакцины дараах мониторинг шинжилгээ хийгдээгүй. | 100% |
